

## Үндэсний давхар даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны 2023 оны ажлын тайлан

Үндэсний давхар даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны 08 дугаар тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг хорооны гишүүн, даргаар томилсон.

Аудитын хорооны даргаар Хараат бус гишүүн Ц.Дашдондог, гишүүнээр Ц.Болорчулуун, С.Мөнхтөр нарыг томилсон.

Тайлант хугацаанд Аудитын хороо нь “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”, “Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын ажиллах журам”-д заасан чиг үүргийн дагуу 5 удаа хуралдаж доорх шийдвэрүүдийг гаргаж Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулж ажилласан. Хорооны хурал гишүүдийн хурлын ирц хангалттай түвшинд байж, хурлын ирц хүрээгүй болон бусад шалтгаанаар хурал хойшилсон асуудал гараагүй болно.

1. 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдөр Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны хурлыг зохион байгуулсан. Тус хурлаар компанийн 2022 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд “Грант торнтон аудит” ХХК-ийн хийсэн санхүүгийн тайлан ба хараат бус аудиторын тайлан, дүгнэлт, удирдлагад хүргэх захидалтай танилцаж, аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг тодорхой төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллах

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны хурлыг 2023 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулсан. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагын баталсан Хэмнэлтийн арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилттэй танилцаж тус хуулийн хэрэгжилтийг Үндэсний давхар даатгал ХК нь хангаж ажилласан байна гэж дүгнэсэн

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны хурлыг 2023 оны 8 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулж Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох тухай 03 дугаар шийдвэр гарсан. Компанийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд аудит хийх эрх бүхий аудитын компанийг сонгох үйл ажиллагааг зохион байгуулахыг гүйцэтгэх захиралд даалгасан.

4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны хурлыг 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулж зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх аудитын байгууллагыг сонгох тухай 04 дагуур шийдэр гарсан. Компанийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд аудит хийх зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх байгууллагаар “Грант Торнтон Аудит” ХХК-ийг сонгосон.

5. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо, Цалин урамшууллын хороодын хамтарсан хурлыг 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан. Хурлаар компанийн 2024 оны төсвийн төсөлтэй танилцаж “Бараа үйлчилгээний бусад зардал”-ын 2,365,475,040 төгрөгөөс Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн 7,316,000 төгрөгийг хасах санал, мөн ажлын байрны түрээсийн төлбөр нэмэгдсэн шалтгаан, “Эрсдэлийн удирдлагын олон улсын форум, эрдэм шинжилгээний хурал” зохион байгуулах, хөндлөнгийн аудитын байгууллагаас өгсөн “СТОУССтандарт-

17"-ыг хэрэгжүүлэх холбоотой зарим асуудлыг ТУЗ-ийн хуралд танилцуулахыг гүйцэтгэх захиралд үүрэг болгож ажилласан

ТАЙЛАН БИЧСЭН:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга



Б.Ангар

ТАНИЛЦСАН:

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга



Ч.Тавинжил

Аудитын хорооны дарга



Н.Дашдондог

Аудитын хорооны гишүүн



Ц.Болорчулуун

Аудитын хорооны гишүүн

С.Мөнхтөр

**Үндэсний давхар даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх  
Цалин, урамшууллын хорооны 2023 оны ажлын тайлан**

Үндэсний давхар даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны 08 дугаар тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг хорооны гишүүн, даргаар томилсон.

Цалин, урамшууллын хорооны даргаар Хараат бус гишүүн С.Мөнхтөр, гишүүнээр Ц.Дашдондог, А.Дэмбэрэл нарыг томилсон.

Тайлант хугацаанд Цалин, урамшууллын хороо нь “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”, “Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын ажиллах журам”-д заасан чиг үүргийн дагуу 2 удаа хуралдаж доорх шийдвэрүүдийг гаргаж Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулж ажилласан. Хорооны хурал гишүүдийн хурлын ирц хангалттай түвшинд байж, хурлын ирц хүрээгүй болон бусад шалтгаанаар хурал хойшилсон асуудал гараагүй болно.

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны хурлыг 2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр зохион байгуулсан. Тус хурлаар компанид мөрдөгдөх “Цалин, урамшууллын бодлогын баримт бичиг”-ийн төсөлтэй хорооны дарга, гишүүд танилцаж, Хөдөлмөрийн тухай хууль, Компанийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоол, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ын 4 дүгээр хавсралт “Цалин, урамшууллын бодлогын үлгэрчилсэн загвар”-тай нийцсэн байна гэж дүгнэсэн

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо, Цалин урамшууллын хороодын хамтарсан хурлыг 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан. Хурлаар компанийн 2024 оны төсвийн төсөлтэй танилцаж “Бараа үйлчилгээний бусад зардал”-ын 2,365,475,040 төгрөгөөс Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн 7,316,000 төгрөгийг хасах санал, мөн ажлын байрны түрээсийн төлбөр нэмэгдсэн шалтгаан, “Эрсдэлийн удирдлагын олон улсын форум, эрдэм шинжилгээний хурал” зохион байгуулах, хөндлөнгийн аудитын байгууллагаас өгсөн “СТОУССтандарт-17”-ыг хэрэгжүүлэх холбоотой зарим асуудлыг ТУЗ-ийн хуралд танилцуулахыг гүйцэтгэх захиралд үүрэг болгож ажилласан.

**ТАЙЛАН БИЧСЭН:**

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга



Б.Ангар

**ТАНИЛЦСАН:**

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга



Ч.Тавинжил

Цалин, урамшууллын хорооны дарга

С.Мөнхтөр

Цалин, урамшууллын хорооны гишүүн



Ц.Дашдондог

Цалин, урамшууллын хорооны гишүүн



А.Дэмбэрэл

## Үндэсний давхар даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн хорооны 2023 оны ажлын тайлан

Үндэсний давхар даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны 08 дугаар тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг хорооны гишүүн, даргаар томилсон.

Эрсдэлийн хорооны даргаар Хараат бус гишүүн Я.Батхандыг, гишүүнээр А.Дэмбэрэл, Д.Насанжаргал, П.Эрдэнэбаатар нарыг томилсон.

П.Эрдэнэбаатар гишүүн өөрийн хүсэлтээр компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс чөлөөлөгдөх хүсэлт өгч 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдөр хувьцаа эзэмшигч, Сангийн сайдын 36 дугаар тушаалаар П.Эрдэнэбаатарыг чөлөөлсөн.

Тайлант хугацаанд Эрсдэлийн хороо нь “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”, “Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын ажиллах журам”-д заасан чиг үүргийн дагуу 4 удаа хуралдаж доорх шийдвэрүүдийг гаргаж Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулж ажилласан. Хорооны хурал гишүүдийн хурлын ирц хангалттай түвшинд байж, хурлын ирц хүрээгүй болон бусад шалтгаанаар хурал хойшилсон асуудал гараагүй болно.

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн хорооны хурлыг 2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулав. Тус хурлаар “Монре даатгал” ХХК-тай байгуулах Малын индексжүүлсэн даатгалын алдагдал зогсоох давхар даатгалын гэрээ болон Трити багцын давхар даатгалын гэрээг сонирхлын зөрчилтэй хэлцэл гэж дүгнэсэн

2. 2023 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн хорооны хурлыг зохион байгуулж, “Монре даатгал” ХХК-тай байгуулах Факультатив хувь оролцооны давхар даатгалын гэрээг сонирхлын зөрчилтэй хэлцэл гэж дүгнэсэн

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн хорооны хурлыг 2023 оны 02 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулж, “Төрийн банк” ХК-тай байгуулах мөнгөн хадгаламжийн гэрээг сонирхлын зөрчилтэй хэлцэл гэж дүгнэсэн

4. 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн хороо, Аудитын хорооны хамтарсан хурлыг зохион байгуулсан. Уг хурлаар компанийн сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах асуудлаар чиглэл, зөвлөмж өгөх эрх зүйн зохицуулалтгүй байна. Иймээс хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг удирдахдаа холбогдох хууль, дүрэм, журам, Сангийн сайдын 2021 оны 66 дугаар тушаалаар өгсөн чиглэлийг анхаарч ажиллах нь зүйтэй гэсэн албан бичгийг компанид хүргүүлсэн.

ТАЙЛАН БИЧСЭН:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга




Б.Ангар

ТАНИЛЦСАН:

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга



Ч.Тавинжил

Эрсдэлийн хорооны дарга  Я.Батханд  
Эрсдэлийн хорооны гишүүн  Д.Насанжаргал  
Эрсдэлийн хорооны гишүүн  А.Дэмбэрэл

**Үндэсний давхар даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх  
Нэр дэвшүүлэх хорооны 2023 оны ажлын тайлан**

Үндэсний давхар даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны 08 дугаар тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг хорооны гишүүн, даргаар томилсон.

Нэр дэвшүүлэх хорооны даргаар З.Энхболд, гишүүнээр Ц.Дашдондог, С.Мөнхтөр нарыг томилсон.

Тайлант хугацаанд Нэр дэвшүүлэх хороо нь “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”, “Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын ажиллах журам”-д заасан чиг үүргийн дагуу 5 удаа хуралдаж доорх шийдвэрүүдийг гаргаж Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулж ажилласан. Хорооны хурал гишүүдийн хурлын ирц хангалттай түвшинд байж, хурлын ирц хүрээгүй болон бусад шалтгаанаар хурал хойшилсон асуудал гараагүй болно.

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны хурлыг 2023 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан. Үндэсний давхар даатгал ХК-ийн 2022 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, гүйцэтгэх удирдлагын ажлын тайлантай тус тус танилцаж гүйцэтгэх захирлын 2022 оны үйл ажиллагааг 94.4 оноогоор “Сайн” гэж дүгнэсэн.

**ТАЙЛАН БИЧСЭН:**

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга



Б.Ангар

**ТАНИЛЦСАН:**

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга



Ч.Тавинжил

Нэр дэвшүүлэх хорооны дарга




З.Энхболд.

Нэр дэвшүүлэх хорооны гишүүн



Ц.Дашдондог

Нэр дэвшүүлэх хорооны гишүүн



С.Мөнхтөр